



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Тагнуулын Ерөнхий газрын саналын дагуу хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

**Төрийн холбоо шуурхай
найдвартай, тасралтгүй байж
чадахгүй байна**

**Төрийн холбооны газарт хэрэгжсэн “Мон-3”
төслийн хэрэгжилт, үр нөлөө**

Агуулга

Ерөнхий зүйл..... 3

Тайланг бэлтгэсэн:

*ҮАГ-ын Нэгдүгээр газрын захирал
Д.Ганбилэг*

Аудитын менежер Ж.Батсайхан

Аудитор С.Андруш

Шинжээч Б.Даваабаатар

1. Аудит хийсэн үндэслэл
2. Аудитын зорилт, хамарсан хүрээ
3. Аудитын арга зүй

Бүлэг 1: Төрийн холбоо шинэчлэгдснээр төсөвт зардал хэмнэгдэх боломж бүрдсэн байна
.....4-7

- 1.1 “Мон-3” төслийн хэрэгжилт
- 1.2 “Мон-3” төслийн үр ашгийг тооцсон байдал

2007 оны 9 дугаар сар

*Уг тайланг ҮАГ-ын
Веб сайт-аас үзнэ үү.*

www.mnao.pmis.gov.mn

Аудитын дүнтэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

Бүлэг 2: Төрийн холбооны шинэчлэгдсэн техник технологи хоцрогдож эхэллээ
.....8-9

- 2.1 Төрийн холбооны телефоныг цаашид нэмэх багтаамжгүй болжээ
- 2.2 Тавигдсан тоног төхөөрөмжийг өргөтгөх завсарлах гэрээ хийгдээгүй байна

Дүгнэлт.....9

Зөвлөмж.....10

*Үндэсний аудитын газар
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс*

Товчилсон үгс:

ҮАГ - Үндэсний аудитын газар

УИХ - Улсын Их Хурал

ТХГ - Төрийн холбооны газар

ТЕГ - Тагнуулын ерөнхий газар

“МЦХ” ХК - Монголын цахилгаан холбоо хувьцаат компани

СЭЗЯ – Санхүү, эдийн засгийн яам /хуучин нэрээр/

НЗДТГ – Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

Ерөнхий зүйл

1. Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Тагнуулын ерөнхий газрын хүсэлтээр Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт, хамарсан хүрээ

Төрийн холбооны газарт хэрэгжүүлсэн "Мон-3" төслийн хэрэгжилтийг шалгаж, түүний үр нөлөөг сайжруулах санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилтыг хангахын тулд дараахь асуудлыг шалгав. Үүнд:

- "Мон 3" төслийн хэрэгжилт, үр нөлөө
- Төрийн холбоог шинэчлэн сайжруулах төслийн хүрээнд тавигдсан суурь сүлжээний техник, технологи, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг дахин өргөтгөх шаардлага байгаа эсэх

Аудитыг "Мон 3" төслийн баримт материал, Төрийн холбооны газрын 2003-2006 оны санхүүгийн тайлан, бусад баримт материалд үндэслэн хийв.

3. Аудитын арга зүй

Аудитад АОУС, Төрийн хянан шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглаж холбогдох баримт материалд тооцоо, судалгаа, дүн шинжилгээ хийн, аудитын дүгнэлт, зөвлөмж гаргав.

Аудитыг Үндэсний аудитын газрын нэгдүгээр газрын захирал Д.Ганбилэг, аудитын менежер Ж.Батсайхан нар удирдаж, аудитор С.Андруш, шинжээч Б.Даваабаатар нар 2007 оны 6 дугаар сарын 18-наас 7 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэв.

Бүлэг 1. Төрийн холбоо шинэчлэгдсэнээр зардал хэмнэгдэх боломж бүрдсэн байна

1.1 "Мон 3" төслийн хэрэгжилт

Төрийн холбооны газар төрийн албаны холбоо, төрийн тусгай холбоо гэсэн 2 үндсэн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байна.

Тус газар нь төр, засгийн харилцаа холбоог тасралтгүй, найдвартай хангах зорилгоор МОН-3 төслийг хэрэгжүүлэн, 2800 хэрэглэгчийн багтаамжтай суурин холбооны STAREX-ARIEL маркын станц болон 800 хэрэглэгчийн багтаамжтай утасгүй хөдөлгөөнт холбооны систем (WLL) гэсэн 2 төрлийн станцыг суурилуулан зүгшрүүлж, УМХГ-ын Улсын комиссын 2006 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн №02/2006 дугаар актаар ашиглалтад хүлээлгэн өгч төрийн байгууллагуудад үйлчилж эхэлсэн байна.

БНСУ-ын Эдийн Засгийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны Сан (ЭЗХХАС-EDCF)-гийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр төрийн холбооны суурь сүлжээг өргөтгөн шинэчлэх төслийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын тохиролцооны баримт бичигт 1996 оны 12 дугаар сарын 6-ны өдөр гарын үсэг зуржээ.

Энэхүү тохиролцооны дагуу Монгол Улсын Санхүү, эдийн засгийн яам (хуучин нэрээр) (СЭЗЯ) болон БНСУ-ын "Экспорт Импорт" буюу (ЭКСИМ) банкны үнэлгээний хэсэг 2000 оны 6 дугаар сарын 14-ний өдөр протокол үйлдэж, зээлийн нөхцөлийг нарийвчлан тохирсон байна.

Дээрх төслийн 79,1 хувийг хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэхээр Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж СЭЗЯ БНСУ-ын "ЭКСИМ" банкттай 2000 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр "МОН-3" дугаар зээлийн хэлэлцээрийг байгуулж, Монгол Улсын Их Хурлын 2001 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаанаар энэхүү зээлийн хэлэлцээрийг соёрхон баталжээ.

Зээлийн хэлэлцээрт зээлийн үндсэн өр болох 5,3 сая ам.доллартай тэнцэх солонгос воныг үндсэн өрийн төлбөрөөс чөлөөлөх хугацаа 10 жил, төлбөр төлөх хугацаа 20 жил, жилийн 2 хувийн хүүтэй, үйлчилгээний хураамж зээлийн үнийн дүнгийн 0,1 хувь бөгөөд үндсэн өрийн төлбөрийг 2011 оноос төлж эхлэн 2030 онд төлж дуусгах нөхцөлүүдийг тусгасан байна.

Уг хэлэлцээрээр төрийн холбооны суурь сүлжээний төв болон орон нутгийн холболтын 23 байгууламж, 79 км кабель шугамыг шинэчлэхээс таван газрыг холбосон 36 км оптик кабель сүлжээ, Улаанбаатар хотод төрийн 34 байруудыг холбосон 40,339 км, аймгуудад 73,4км физик кабель, бүгд 149,7 км кабелийг татсан байна.

БНСУ-ын ЭЗХХАС тус улсын компаниудын дунд нээлттэй тендер зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан "Самсунг" компанитай Төрийн холбооны газар 2001 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр төсөл хэрэгжүүлэх гэрээ байгуулжээ.

Зээлийн ашиглалтыг хэрхэн төлөвлөснийг зардлын зүйл тус бүрээр доорх хүснэгтэд үзүүлэв:

(Мянган ам.доллараар)

Ангилал	Зарцуулах мөнгөний тооцоо
(А) Бараа, үйлчилгээний бэлтгэн нийлүүлэлт (гадаад валютын хэсэг)	5030.0
1. PABX - Холбох систем (23 нэгж) - Цэнэглэх систем - ОМ ба удирдлага - UTP кабель	2436.0
2. WLL - Дотоод систем (4 ком) - Станц FWT FWD , Mobile - Эрчим хүчний хангамж ба бусад	1313.0
3. OSP - Шилэн кабель - Зэс кабель - Засварын тоног төхөөрөмж	422.0
4. Суурилуулах ба шалгах	500.0
5. Удирдах, сургах	359.0
(Б) Үйлчилгээний хураамж	5.0
(В) Болзошгүй зардал	265.0
ДҮН	5300.0

“Мон-3” төслийн хөрөнгийн зарцуулалт

(Ам.доллараар)

№	Суурилагдсан төхөөрөмжүүд	Үндсэн өртөг	Ажил, үйлчилгээний зардал, сургалт	Нийт мөнгөн дүн
1	Төв, орон нутгийн суурин станцууд, тэдгээрийн дагалдах техник төхөөрөмжүүд	2,207,921.20	308,850.00	2,516,771.20
2	WLL болон дамжуулах систем	1,258,721.67	237,110.00	1,495,831.67
3	Кабель, шугам	774,641.04	240,565.00	1,015,206.04
	Бүгд дүн			5,027,808.91

“Мон-3” төслийн гүйцэтгэгч Солонгос Улсын “Самсунг” компани дээрх 5,027,808.91 ам.долларын хөрөнгийг Төрийн холбооны газарт хүлээлгэн өгснөөс Төрийн өмчийн хорооны 2007 оны 133 дугаар тогтоолоор 59,948,299 төгрөг буюу 4,101,696,245.0 воны хөрөнгийг орлогод авахыг зөвшөөрч, 1,013,190,713.0 воны хөрөнгийг төсөл хэрэгжих хугацаанд зарцуулж дууссан тул бүртгэлд тусгаагүй байна.

Солонгосын тал магадлашгүй ажлын зардалд тусгагдсан 265.0 мянган ам.долларыг төв, орон нутгийн станцуудад дуудлагын төхөөрөмж буюу “Call convertor 90” комплектыг бэлтгэн нийлүүлж, угсарч суурилуулахад зарцуулжээ.

2003 онд “Мон-3” төсөл хэрэгжиж дууссанаар 1974 онд суурилагдсан 1500 хэрэглэгчийн багтаамжтай холбооны АТС станцийг сольж, төрийн холбооны төв, орон нутгийн сүлжээний төхөөрөмжүүд, төрийн сүлжээний кабель шугам бүхэлдээ солигдож, техник технологийн хувьд шинэчлэгдсэн байна.

1.2 “Мон 3” төслийн үр ашгийг тооцсон байдал

“Мон-3” төслийн анхны захиалагч Дэд бүтцийн яам татан буугдаж, хариуцагчгүй болсон тул Төрийн холбооны газар уг төслийг хариуцан ажилласан байна.

Төслийн хүрээнд техник, тоног төхөөрөмж, кабель болон бусад материалыг хамрагдах бүх аймаг, Улаанбаатар хотод угсарч суурилуулсан гэж Сангийн яам бүртгэсэн байна.

Төслийн үндсэн зорилго нь төрийн байгууллагуудын хооронд холбооны сүлжээ байгуулах, байгуулсан сүлжээн дотроо үнэ төлбөргүй ярьж, эдгээр байгууллагуудын холбооны зардлыг бууруулах явдал байжээ.

“Мон-3” төсөл хэрэгжсэнээр 2003-2006 онуудад үүссэн зарим хэмнэлтийг тоон үзүүлэлтээр харуулбал:

/Төгрөгөөр/

1	Харилцан холболтын ярианаас үүссэн хэмнэлт	17,495,928
2	Суурин хэрэглэгчдийн сарын суурь хураамж чөлөөлөгдсөнөөс гарах хэмнэлт	697,714,200
3	Сүлжээн доторхи үнэгүй яриа	207,503,815
4	“МЦХ” ХК-тай бусад оператор компаниудын адил харилцан холболтын зарчмаар тооцоо хийдэг байсан бол төлбөрийн хэмнэлт	112,205,344
	Дүн	1,034,919,287

Дээрх хүснэгтээс харахад сүүлийн 3 жилд “Мон-3” төсөл хэрэгжсэнээр 1,034 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна (Аудитын явцад зөвхөн дээрх дөрвөн хэмнэлтийг авч үзсэн болно). Үүнд:

1. “Мон-3” төслийг хэрэгжүүлсэнээр Төрийн холбооны ярианы орлого 2003 - 2006 онд 70% буюу 8,395,390 төгрөгөөр өсөж 17,495,928 төгрөгийн хэмнэлт гарсан байна. “Хавсралт №1”

2. “Мон-3” төсөл хэрэгжиж суурин ба утасгүй хэрэглэгчдийн (26, 92)-оор эхэлсэн телефон утасны сарын суурь хураамж чөлөөлөгдсөнөөр 697,714,200 төгрөг хэмнэснийг “Хавсралт №2”-д үзүүлэв.

3. 2003-2006 онд Төрийн холбооны сүлжээн доторх яриа /26-26/-д 42%-иар, /26-9200/-д 53%-иар, /9200-9200/-д 21%-иар тус тус нэмэгдсэн буюу “МЦХ” ХК-ны хэрэглэгч байсан бол дээрх дуудлагуудын тоог энгийн утасны тариф 10 төгрөгөөр

бодож, НӨТ төлнө гэж тооцвол 207,503,815 төгрөг хэмнэснийг "Хавсралт №3"-д үзүүлэв.

4. "МЦХ" ХК-тай хийх сүлжээ хоорондын харилцан холболтын гэрээг Харилцаа холбооны зохицуулах хорооны 2006 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлагдсан "Цахилгаан холбооны сүлжээнд холбогдох, сүлжээ хоорондын харилцаа холболтын журам"-ын 2.2-д "Цахилгаан холбооны сүлжээнд холбогдох харилцан холболт хийхдээ талууд ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцөлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх зарчмыг баримтлана", 2.3-д "Талууд өрсөлдөөний эсрэг аливаа үйлдэл гаргахгүйгээр шударга өрсөлдөх зарчмыг баримтлана" гэсэн заалтуудын дагуу хийвэл 112,2 сая төгрөг хэмнэхийг "Хавсралт №4"-д үзүүлэв.

Жилд 345.0 сая төгрөгийн хэмнэлт гаргана гэж тооцвол үндсэн төлбөр болох 5,9 тэрбум төгрөгийг 17 жилийн дараа нөхөж дуусгахаар байна.

Бүлэг 2. Төрийн холбооны шинэчлэгдсэн техник технологи хоцрогдож эхэллээ

2.1 Төрийн холбоонд тавигдсан телефоныг цаашид нэмэх багтаамжгүй болжээ

"Мон-3" төсөл 2003 оноос хэрэгжсэн бөгөөд тухайн үед Төрийн холбооны газрын сонгосон техник, тоног төхөөрөмж, хэрэглэж буй технологи мэдээлэл, харилцаа холбооны хурдацтай хөгжлийн жамаар хоцрогдож байна.

Утасгүй телефоны системийн ажиллаж байгаа тусгай зөвшөөрөлтэй долгион нь IMT2000 олон улсын зурваст хамаарагддаг бөгөөд өргөн зурвасаар өндөр хурдаар олон төрлийн холбооны үйлчилгээг үзүүлэх боломжтойгоороо онцлог юм. Төрөөс бодлогоор олгогдсон энэхүү зурвасыг үр ашигтай ашиглахын тулд одоогийн системд технологийн шинэчлэл хийх шаардлага байна.

Мэдээллийн технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед төрийн албан хаагчдад олон төрлийн нэмэлт үйлчилгээг (өндөр хурдаар өгөгдөл дамжуулах, байрлал тогтоох, дүрсээ харж ярих гэх мэт) үзүүлэх шаардлага бий.

Холбооны бусад операторуудтай сүлжээ хоорондын харилцан холболт хийдэг төрийн үндсэн суурин станц нь дотоод холбооны зориулалттай РАВХ бөгөөд одоогоор шинээр байгуулагдсан компаниудтай шууд холболт хийх техникийн боломжгүй байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын хэрэглэгчдийн төгсгөлийн төхөөрөмжийн нууцлалыг хангах шаардлагатай байна.

21 аймаг, нийслэлийн төрийн сүлжээний хувьд өгөгдөл болон яриаг зэрэг дамжуулах боломжгүй, өгөгдөл дамжуулах сувгийн хурд хүрэлцэхгүй байна.

Төрийн холбооны газрын үйлчилгээний дүрэм, зааврыг Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 10 дугаар тогтоолоор баталсан байна.

Утасгүй телефоны системийг дээрх тогтоолын дагуу төрийн өндөр албан тушаалтан хэрэглэх ёстой боловч тэднээс гадна албан хүсэлтээ гаргасан төр, захиргааны байгууллагууд мөн ашиглаж байна.

Тус газар үйлчлүүлэгч байгууллагаас ирүүлсэн албан бичгийг үндэслэн дугаар олгодог бөгөөд албан тушаалтнууд өөрийн нэр дээр аваад өөр бусдад шилжүүлэн ашиглуулж байгаад хяналт тавьдаггүй байна.

Хэрэглэгчдийн тоо хязгаарлагдмал, зөвхөн албан ажилд хэрэглэгддэг онцлогтой тул цаашид гар утас хэрэглэх эрх бүхий төр, захиргааны байгууллагуудын жагсаалт, тэдгээрийн квотыг шинэчлэн батлах шаардлагатай байна.

Төрийн сүлжээний хэрэглэгч болохыг хүссэн төрийн байгууллагын тоо нэмэгдсээр байна. Гэтэл 833 утасгүй телефон хэрэглэгчдийн 31% буюу 255-ыг нь тагнуулын ерөнхий газар хэрэглэж байна.

Хэрэглэгчдийн тогтоосон лимит дууссан тохиолдолд станц дээр хязгаарлалтыг хийж үйлчилгээг хааж байгаа нь шугам хүрэлцэхгүйтэй холбоотой байна.

2.2 Тоног төхөөрөмжийг өргөтгөх, засварлах гэрээ хийгдээгүй байна

Үндсэн суурин станцын чанарын үзүүлэлтийг станцын ачааллын судалгааг үндэслэж тодорхойлдог тул өдөр бүр ачааллын судалгааг бүртгэж станцын амжилттай дуудлагын хувь болон холбох шугамд үүсэх ачаалалд анализ хийдэг байна. Судалгаанаас үзэхэд суурин станцын амжилттай дуудлагын хувь сайн, холбох 1 шугамд үүсэх ачаалал одоогийн байдлаар хэвийн байна.

9200xxxx дугаартай утасгүй телефон системийн хэрэглэгчдийн хувьд сүлжээний хамрах хүрээ бага буюу дамжуулах төв станцуудын тоо цөөн учраас орох дуудлага амжилтгүй болох тохиолдол их байдаг ч төслийн хүрээнд суурилуулсан техникийн боломжийн хэмжээнд ажиллаж байна.

Төрийн холбооны суурин болон утасгүй телефон утасны станцуудын хувьд бусад станцуудын адил дуудлага шилжүүлэх, дугаар илрүүлэх, гарах дуудлага хаах ба нээх зэрэг нэмэлт үйлчилгээг авах бүрэн боломжтойгоос гадна суурин станц нь бие даасан дуут шуудангийн үйлчилгээ үзүүлж байна.

Төвөөс орон нутгийн чиглэл бүрт нэг сувагтай байгаа нь хугацааны нэг агшинд нэг хэрэглэгч ярьж байхад бусад хэрэглэгч хүлээх болдог нь шаардлагад нийцэхгүй байна.

Төрийн холбооны үндсэн станцууд тэдгээрийн дагалдах төхөөрөмжүүдийн хэвийн найдвартай, тасралтгүй байдлыг хангах техникийн дэмжлэг туслалцаа авах, "Мон-3" төслийн төхөөрөмжүүдийг үйлдвэрлэдэг гадаадын харилцагч зайлшгүй шаардлагатай.

Гэтэл “Мон-3” төслийн ашиглалт, үйлчилгээний гэрээ хөрөнгө мөнгөний асуудлаас болж одоог хүртэл хийгдээгүй байна.

Аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. 9200xxxx дугаартай утасгүй телефоны системийн хэрэглэгчдийн хувьд шуурхай найдвартай, тасралтгүй байдлыг хангахад сүлжээний хамрах хүрээ бага, дамжуулах төв станцуудын тоо 3 байгаа нь хангалтгүй бөгөөд 800 орчим хэрэглэгчийн багтаамжтайгаас 840 хэрэглэгчтэй болсон тул станцад шинээр хэрэглэгч нэмэх боломжгүй, орох дуудлага амжилтгүй болж, хэрэглэгч завгүй, хариу өгөөгүй, яриа тасалдах, сүлжээ унах, тэжээлээс

салсан, буруу дугаар цуглуулсан гэх мэт дутагдалууд гарч хэрэглэгчдийг бухимдуулж шаардлага хангахгүй байна.

2. Агааржуулалт, хөргөлтийн системүүд нь байнгын ашиглалтын горимд ажилладаг учраас 2.5-3 жил ажиллах нормтой тул цаашид үргэлжлүүлэн ашиглах боломжгүй болсон ба холбооны бусад операторуудтай сүлжээ хоорондын харилцан холболт хийдэг төрийн үндсэн суурин станц нь дотоод холбооны зориулалттай (РАВХ) бөгөөд шинээр байгуулагдсан компаниудтай шууд холболт хийх техникийн боломжгүй байна. Мөн төвөөс орон нутгийн чиглэл бүрт нэг сувагтай байгаа нь хугацааны нэг агшинд нэг хэрэглэгч ярьж байхад бусад хэрэглэгч хүлээх болдог нь өнөө үед тавигдаж байгаа мэдээлэл холбоо хурдан шуурхай байх гэсэн шаардлагад нийцэхгүй байна.

3. Төлбөр тооцооны системийн хувьд байгууллагаас тогтоосон лимит дууссан тохиолдолд станц дээр хязгаарлалтыг механикаар хийдэг учраас урьдчилсан төлбөрт системийн үйлчилгээ дутагдаж байна.

4. Төсөв хөрөнгийн хүрэлцээгүйгээс мэдээлэл, харилцаа холбооны салбарт гарч буй техник, технологийн хөгжлийн хурдаас хоцорч байгаа нь Төрийн холбоо шуурхай найдвартай, тасралтгүй байж чадахгүй байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доорх албан тушаалтанд зөвлөж байна.

Тагнуулын ерөнхий газрын дарга Н. Ганболдод

- 9200 дугаартай гар утас хэрэглэх эрх бүхий төр, захиргааны байгууллагуудын албан тушаалтны жагсаалтыг шинэчлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.
- Төрийн байгууллагуудад тогтоосон ярианы төлбөрийн лимит дууссан үед урьдчилсан төлбөрт үйлчилгээг нэвтрүүлэх.



ТӨРИЙН ХОЛБООНЫ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ Б.БАТБАЯР
ТАНАА

210646-74, Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Жуулчны гудамж-3,
Утас: 266888, Факс: 264429

2007.10.09 № 03/223
танай 2007.10.03 -ны № 1/340 -Т

Санал хүргүүлэх тухай


Тус газарт хэрэгжсэн "МОН-3" төсөлд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Тайлангийн төслийн 5 дугаар хуудсан дахь 2003-2006 онуудад үүссэн зарим хэмнэлтийн тоон үзүүлэлтийг 6 дахь хуудасны дээрээсээ 3,4 дэх мөрөнд бичсэнтэй харьцуулж үзэх;
2. "Бүлэг2"-ийн 2.1-ийн гарчгийг "Төрийн холбоонд МОН-3 төслөөр угсарч суурилуулсан суурин болон утасгүй холбооны системүүд оргил ачаалалдаа хүрсэн тул телефон хэрэглэгчдийн тоог цаашид нэмэх багтаамжгүй болжээ" гэж өөрчлөх;
3. Мөн тайлангийн 6 дугаар хуудасны 11,12 дахь мөрийг "... байгууллагуудын хэрэглэгчдийг мэдээлэл нууцлах холбооны төгсгөлийн төхөөрөмжөөр хангах..." гэж найруулах;
4. Мөн тайлангийн төслийн 7 дугаар хуудасны дээрээсээ 7 дахь мөрийг "...станц дээр хязгаарлалтыг механик (гар аргаар)-аар хийж, ..." гэж найруулах;
5. Мөн 7 дугаар хуудасны 15 дахь мөрөнд буйг "... нэг телефон сувагтай байгаа нь...", 8 дугаар хуудасны 6 дахь мөрөнд "...чиглэл бүрт нэг телефон сувагтай байгаа нь ..." гэж тус тус найруулах;
6. "Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна" гэдэгт энэхүү тайлангийн "Бүлэг2"-т зааснаас мэдээлэл, харилцаа холбооны салбарт гарч буй техник, технологийн хөгжлийн хурдаас хоцорч байгаа нь "Төрийн холбоо шуурхай найдвартай, тасралтгүй байж чадахгүй байна" гэж дүгнэв гэсэн утга агуулгатай заалт нэмүүлэх;

Таныг хүндэтгэсэн



ДАРГА,
ХУРАНДАА


Г. ТӨМӨРСҮХ

Харилцан холболтын ярианаас үүссэн хэмнэлт

Хавсралт -1

Он	
2003	121597
2004	489996
2005	8367348
2006	8516987
Дүн	17,495,928

Суурин ба утасгүй телефоны цэгийн өсөлт

Он	Суурин телефон цэгийн тоо	Утасгүй телефон цэгийн тоо
2003	1750	250
2004	2543	540
2005	2655	779
2006	2686	833

Суурин хэрэглэгчдийн сарын суурь хураамж чөлөөлөгдсөнөөс гарсан хэмнэлт

Хавсралт-2

Он	Телефон цэгийн тоо		Нэг телефон цэгийн нэг сарын суурь үнэ НӨАТ-ын хамт ₮		Сард төлөх		Жилд төлөх	
	Суурин хэрэглэгч	Утасгүй телефон	Суурин хэрэглэгч	Утасгүй телефон	Суурин хэрэглэгч	Утасгүй телефон	Суурин хэрэглэгч	Утасгүй телефон
2003	1750	250	5175	3450	9056250	862500	108675000	10350000
2004	2543	540	5175	3450	13160025	1863000	157920300	22356000
2005	2655	779	5175	3450	13739625	2687550	164875500	32250600
2006	2686	833	5175	3450	13900050	2873850	166800600	34486200
					49855950	8286900	598271400	99442800
Бүгд дүн							697,714,200.00	

Сүлжээн доторхи үнэгүй яриа

Хавсралт-3

Ярианы чиглэл	2003-2006 онуудад хийгдсэн нийт дуудлагын тоо	Энгийн утасны тариф /₮/	Хэмнэгдсэн дүн /₮/	НӨАТ 15%	Нийт хэмнэлт /₮/
Суурин хэрэглэгчдийн хооронд (26<->26)	14227809	10	142.278.090	21.314.713	163.619.803
Суурин болон утасгүй телефоны хэрэглэгчдийн хооронд (26<->9200)	2757695	10	27.576.950	4.136.542	31.713.492
Утасгүй телефоны хэрэглэгчдийн хооронд (9200<->9200)	1058306	10	10.583.060	1.587.459	12.170.519
					207.503.815

“МЦХ” ХК-тай бусад оператор компаниудын адил харилцан холболтын зарчмаар тооцоо хийдэг байсан бол доорхи хэмнэлт гарах болжээ

Хавсралт-4

“МЦХ” ХК-ний сүлжээнээс ТХГ-ын сүлжээ рүү орсон яриа:

Ярианы чиглэл	2004 он		2005 он		2006 он		Бүгд
	Үргэлжилсэн хугацаа /мин/	ТХГ-т төлөх төлбөр /₮/	Үргэлжилсэн хугацаа /мин/	ТХГ-т төлөх төлбөр /₮/	Үргэлжилсэн хугацаа /мин/	ТХГ-т төлөх төлбөр /₮/	
“МЦХ” ХК-ны хэрэглэгчээс ТХГ руу	1805686	17,880,805	2275358	22,531,732	2525858	25,012,308	65,424,847

Төрийн холбооны газраас “МЦХ” ХК-ийн сүлжээ рүү гарсан яриа:

Ярианы чиглэл	2004 он		2005 он		2006 он		Бүгд
	Үргэлжилсэн хугацаа /мин/	“МЦХ”ХК-д төлсөн төлбөр /₮/	Үргэлжилсэн хугацаа /мин/	“МЦХ”ХК-д төлсөн төлбөр /₮/	Үргэлжилсэн хугацаа /мин/	“МЦХ”ХК-д төлсөн төлбөр /₮/	
ТХГ-аас “МЦХ”ХК-ны	2324532	33,957,896	339389	69,147,354	398424	74,524,941	177,630,191

хэрэглэгч рүү							

Саналд өгөх тайлбар

Тайлбар 1: 1,034,9сая төгрөг нь 3 жилийн хэмнэлт болно. ($1,034,9 : 3 = 345,0$)

Тайлбар 2: “Бүлэг 2”-ийн 2.1-ийн гарчигт энэ өгүүлбэр байгаа.

Тайлбар 3: “Нууцлах холбооны төгсгөлийн төхөөрөмжөөр хангах” гэдэг агуулга тайланд тусгагдсан байгаа.

Тайлбар 4: 7 дугаар хуудасны 7 дахь мөрөнд бичигдсэн болно.

Тайлбар 5: 8 дугаар хуудасны 6 дахь мөрөнд адил утгатай байна.

Тайлбар 6: Бүлэг 2,1-т бичсэнийг дүгнэлтэнд дэлгэрэнгүй тайлбарласан болно.

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн Тушаах нь:

Нэг. Тагнуулын ерөнхий газрын Төрийн холбооны газарт хэрэгжсэн “Мон-3” төслийн хэрэгжилт, үр нөлөөнд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Тагнуулын ерөнхий газрын дарга Н.Ганболд, Төрийн холбооны газрын дарга Г.Төмөрсүх нарт хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч түүний үр дүнг 2007 оны 12 дугаар сарын 31-ний дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Төрийн холбооны газрын дарга Г.Төмөрсүхэд зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА